



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/150/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Гэрэлт Хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор Б.Бадамцэцэг Утас:99062042 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 214
танай _____ -ны № _____ -т

ЦЭЦЭГ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ДАНШИГМАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Хагас бүтэн жилээр бараа материалын болон хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, няравын тайлан гаргаагүй,
- Үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тогтоолд заасан хувиас илүү олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчид ур чадвар, үр дүн олгосон,
- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр няравын дансаар ХХОАТ суутган зардал гаргасан,

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд сумын хэмжээнд урлаг, уран бүтээлийн арга хэмжээг зохион байгуулж, Үенч суманд зохион байгуулсан 14 сумдын соёлын төвийн ажилтны туршлага судлах арга

хэмжээнд оролцсон байна. Онцлох асуудал нь тайлант онд заалаа урлагын тоглолт болон бусад арга хэмжээнд түрээслэн 4.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	1,338,724.97	4,487,700.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,338,724.97	11,441.70
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	2,125,058.44
335	Бусад авлага	0.00	2,351,200.00
33510	Байгууллагаас авах авлага	0.00	2,351,200.00
34	УРЬДЧИЛГАА	180,000.00	180,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	180,000.00	180,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,391,450.00	11,865,778.00
351	Түүхий эд материал	0.00	4,594,328.00
35110	Тусгай зориулалттай материал	0.00	4,594,328.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,952,650.00	5,832,650.00
354	Хангамжийн материал	1,438,800.00	1,438,800.00
35410	Бичиг хэргийн материал	355,900.00	355,900.00
35420	Аж ахуйн материал	18,000.00	18,000.00
35450	Барилгын засварын материал	38,000.00	38,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,026,900.00	1,026,900.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,910,174.97</u>	<u>16,533,478.14</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,976,943,208.48	1,879,751,016.83
39100	Газар	2,326,000.00	5,826,000.00
392	Биет хөрөнгө	1,971,299,995.00	1,873,550,016.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,743,968,132.00	1,743,968,132.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-137,379,500.65	-167,544,162.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	271,281,800.22	271,281,800.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-35,697,534.92	-84,553,523.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	129,935,396.50	125,341,068.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,395,506.15	-39,380,505.80
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,082,700.00	5,082,700.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	600,000.00	600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-150,000.00
39217	Ном	18,904,508.00	18,904,508.00
393	Биет бус хөрөнгө	3,317,213.48	375,000.00
39301	Програм хангамж	1,957,000.00	1,957,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,207,000.00	-1,582,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,500,000.00	0.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-932,786.52	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,976,943,208.48</u>	<u>1,879,751,016.83</u>
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,984,853,383.45</u>	<u>1,896,284,494.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	122,412.97	2,812,625.96
413	Өглөг	122,412.97	2,812,625.96

Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	67,412.97	938,375.96
4136	Бусад өглөг	55,000.00	1,874,250.00
41361	Байгууллагад төлөх өглөг	55,000.00	1,874,250.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>122,412.97</u>	<u>2,812,625.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,984,730,970.48	1,893,471,869.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	248,091,348.00	248,091,348.00
51101	Өмч: - төрийн	248,091,348.00	248,091,348.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,632,067,381.56	1,540,808,280.09
51210	Өмнөх үеийн үр дүн	1,411,517,664.71	1,632,189,238.59
51220	Тайлант үеийн үр дүн	220,549,716.85	-91,380,958.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	104,572,240.92	104,572,240.92
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,984,730,970.48</u>	<u>1,893,471,869.01</u>
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,984,853,383.45</u>	<u>1,896,284,494.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,750,202.59	289,264,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	234,506,402.59	179,388,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	234,506,402.59	179,388,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,043,800.00	109,875,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,043,800.00	109,875,800.00
1330	Төсвийн захирагчдаас	200,000.00	0.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	200,000.00	0.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	294,841,814.22	9,053,328.00
120	Нийтлэг татварын бус орлого	294,841,814.22	9,053,328.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	4,459,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,459,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	281,533,414.22	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,308,400.00	4,594,328.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	651,592,016.81	298,317,428.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,707,312.96	389,698,386.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,258,724.67	376,710,765.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,650,803.84	147,146,051.90
210101	Үндсэн цалин	81,151,892.69	90,335,930.70
210102	Нэмэгдэл	39,546,381.15	46,705,320.92
210104	Урамшуулал	9,952,530.00	10,104,800.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,158,928.16	19,583,992.63
210201	Тэтгэврийн даатгал	11,105,318.83	12,598,210.08

Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	1,221,427.33	1,412,291.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	610,713.68	706,145.74
210204	Ажилгүйдлийн даатгал	608,452.12	1,903,060.58
210205	Эрүүл мэндийн даатгал	2,613,016.20	2,964,284.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,567,507.00	98,461,828.52
210301	Гэрэл, цахилгаан	2,048,207.00	2,674,708.52
210302	Түлш, халаалт	80,359,300.00	95,567,120.00
210303	Цэвэр, бохир ус	160,000.00	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,764,296.76	5,215,300.00
210401	Бичиг хэрэг	3,324,500.00	1,674,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,287,700.00	2,986,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	697,096.76	150,000.00
210404	Ном, хэвлэл	70,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,385,000.00	405,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,935,900.00	2,788,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,090,000.00	1,188,500.00
210604	Урсгал засвар	12,845,900.00	1,599,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,096,400.00	375,000.00
210702	Дотоод албан томилолт	1,096,400.00	375,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,208,000.00	1,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,068,000.00	1,450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,140,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,876,888.91	101,540,141.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,222,000.00	4,226,093.29
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,654,888.91	97,314,048.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,448,588.29	12,987,621.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,235,128.00	881,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	835,898.00	881,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,628,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	770,930.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	12,105,921.48
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	10,609,621.48
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,496,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,213,460.29	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,213,460.29	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	420,707,312.96	389,698,386.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>230,884,703.85</u>	<u>-91,380,958.50</u>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,334,987.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,334,987.00	0.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,334,987.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>220,549,716.85</u>	<u>-91,380,958.50</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,750,202.59	289,264,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	233,201,402.59	179,388,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	233,201,402.59	179,388,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,305,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,305,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	122,043,800.00	109,875,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	122,043,800.00	109,875,800.00
1330	Төсвийн захирагчдаас	200,000.00	0.00
133004	Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт	200,000.00	0.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	0.00	4,459,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	4,459,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	4,459,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,459,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	356,750,202.59	293,723,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	357,055,830.03	293,723,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,607,241.74	278,610,420.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	133,626,337.98	147,611,841.56
210101	Үндсэн цалин	80,012,500.00	88,837,052.55
210102	Нэмэгдэл	42,660,437.98	49,958,389.01
210104	Урамшуулал	10,953,400.00	8,816,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,404,254.00	17,057,800.00
210201	Тэтгэврийн даатгал	9,831,200.00	11,630,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,156,600.00	1,356,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	578,200.00	678,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	578,200.00	678,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,260,054.00	2,713,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,136,053.00	98,461,828.52
210301	Гэрэл, цахилгаан	2,616,753.00	2,674,708.52
210302	Түлш, халаалт	80,359,300.00	95,567,120.00
210303	Цэвэр, бохир ус	160,000.00	220,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,819,996.76	4,376,300.00
210401	Бичиг хэрэг	600,000.00	1,449,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,700,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,449,996.76	876,500.00
210404	Ном, хэвлэл	70,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	0.00

Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	250,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,293,600.00	4,951,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,743,600.00	3,351,200.00
210604	Урсгал засвар	3,550,000.00	1,599,950.00
2107	Томилолт, зочны зардал	1,096,400.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	1,096,400.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,168,500.00	2,639,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,848,500.00	2,489,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,320,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,562,100.00	2,762,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,562,100.00	2,762,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,448,588.29	15,112,679.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,235,128.00	881,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	835,898.00	881,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,628,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	770,930.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	14,230,979.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	12,734,679.92
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	1,496,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	54,213,460.29	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	54,213,460.29	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>357,055,830.03</u>	<u>293,723,100.00</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>-305,627.44</u>	<u>0.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,150,000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,150,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,150,000.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,150,000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3,150,000.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-3,455,627.44	0.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,455,627.44	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	248,091,348.00	104,572,240.92	1,404,576,783.21	1,757,240,372.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	6,940,881.50	6,940,881.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	248,091,348.00	104,572,240.92	1,411,517,664.71	1,764,181,253.63
C09	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	220,782,363.37	220,782,363.37
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,091,348.00	104,572,240.92	1,632,300,028.08	1,984,963,617.00
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	248,091,348.00	104,572,240.92	1,632,300,028.08	1,984,963,617.00
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	121,857.03	121,857.03
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	248,091,348.00	104,572,240.92	1,632,421,885.11	1,985,085,474.03
C19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-91,380,958.50	-91,380,958.50
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	248,091,348.00	104,572,240.92	1,541,040,926.61	1,893,704,515.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	179,388,300.00	167,282,378.52
122005	Төсвөөс санхүүжих	179,388,300.00	167,282,378.52
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,875,800.00	109,875,800.00
132003	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	109,875,800.00	109,875,800.00
12000	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	4,459,000.00	4,459,000.00
120004	Үндсэн үйл ажиллагааны орлого	4,459,000.00	4,459,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	293,723,100.00	281,617,178.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	293,723,100.00	281,617,178.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,841,400.00	280,735,478.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,606,100.00	147,611,841.56
210101	Үндсэн цалин	88,997,400.00	88,837,052.55
210102	Нэмэгдэл	50,008,600.00	49,958,389.01
210104	Урамшуулал	9,600,100.00	8,816,400.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,575,700.00	17,057,800.00
210201	Тэтгэврийн даатгал	12,662,900.00	11,630,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,478,200.00	1,356,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	739,100.00	678,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	739,100.00	678,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,956,400.00	2,713,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,875,800.00	98,461,828.52
210301	Гэрэл, цахилгаан	4,375,800.00	2,674,708.52
210302	Түлш, халаалт	103,680,000.00	95,567,120.00
210303	Цэвэр, бохир ус	220,000.00	220,000.00
210304	Байрны түрээс	1,600,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,810,200.00	4,376,300.00
210401	Бичиг хэрэг	360,000.00	1,449,800.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	1,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	876,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200.00	250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,951,200.00	4,951,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,351,200.00	3,351,200.00
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,599,950.00
2107	Томилолт, зочны зардал	750,000.00	750,000.00
210702	Дотоод албан томилолт	750,000.00	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,509,000.00	4,764,058.44
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	5,359,000.00	4,614,058.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,763,400.00	2,762,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,763,400.00	2,762,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	881,700.00	881,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	881,700.00	881,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	881,700.00	881,700.00
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	293,723,100.00	281,617,178.52

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,356.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 16,938.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данснаас 4594,3 мянган төгрөгийн урлагийн хувцас, хэрэгслийг бараа материалын дансанд шилжүүлэн бүртгээгүй,
- Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд 2125,1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлснээр тусгасан,
- Тайлант онд 3500,0 мянган төгрөгийн үнэтэй газрыг бусад биет хөрөнгөөр тусгаж, элэгдэл тооцсон,
- Тайлант оны үр дүнг 6,719,4 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 18,417.7 мянган төгрөгийн 3 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 18,417.7 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 2,622.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 15,794.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага нь албан хаагчдын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тогтоосон хувиас илүү бодож олгосон, үр дүнгийн урамшуулалт цалинг, тушаал шийдвэргүй олгосон, сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүн, ур чадвар олгосон, Цэцэрлэгийн эрхлэгчид сумын ЗД-ын захирамжаар 1,2 дугаар улиралд ур чадварын нэмэгдэл зэрэг нийт 2,622.825 төгрөгийг бодож олгосон нь “Соёлын сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/166, А/163, А/73 тоот хамтарсан тушаалын 9-д “Соёл, урлагийн салбарын удирдах албан тушаалтан буюу төсвийн шууд захирагч нарын ур чадварын нэмэгдлийг соёл, урлагийн газрын дарга үнэлж дүгнэн шийдвэрлэнэ”, “Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

3.2.1 Үндсэн хөрөнгө бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 14,250.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, бараа материалын тайлан гаргаагүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”:, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д " зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3--д " илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.6-д ".дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” “Үнэн зөв байдал”, ”Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд хийж хэвших, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үр дүн тооцон ажиллах

3.2.2 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нярвын харилцах дансаар олон нийтэд чиглэсэн ажил арга хэмжээний зардлыг ашгийн татвар суутган олгосон, анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй и-баримтгүй, нярвын дансаар гүйлгээ хийсэн 1544,3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ," Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.6-д ".дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; гэсэн заалтуудтай нийцээгүй, “Үнэн зөв байдал”, ”Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрдүүлж, тайлан гаргаж, тооцоо бодож хэвших, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын

төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Цэцэг сумын Соёлын төв	Үндсэн хөрөнгөөс бараа материалд шилжүүлж бүртгэлд тусгаагүй	1	4,594.3			1	4,594.3	1	4,594.3				
	Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд төсөвт төвлөрүүлснээр тусгасан	1	2,125.1			1	2,125.1	1	2,125.1				
	Тайлант онд газрыг бусад биет хөрөнгөөр тусгаж, элэгдэл тооцсон	1	3,500.0			1	3,500.0	1	3,500.0				
	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй тусгасан	1	6,719.4			1	6,719.4	1	6,719.4				
	Дүн	4	16,938.8			4	16,938.8	4	16,938.8	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшууллын нэмэгдлийг ажилчдад илүү хувиар олгосон, тушаал шийдвэргүй үр дүн олгосон	1	2,622.8	1	2,622.8					-	-	-	-
Үндсэн хөрөнгө бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, бараа материалын тайлан гаргаагүй	1	14,250.6					1	14,250.1				
Анхан шатны баримтын бүрдэлгүй няравын дансаар мөнгө дамжуулан олгосон	1	1,544.3					1	1,544.3				
Дүн	3	18,417.2	1	2,622.8	-	-	2	15,794.4				-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ	1	1				1			

Цэцэг сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	НИЙТ	1	1				1		
--	-------------	----------	----------	--	--	--	----------	--	--